



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/ҮЗ

Улаанбаатар хот

“Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх
жил”-ийн нээлтийн арга хэмжээг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”, нийслэлээс “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил”, дүүргээс “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан, зорилтот жилийн төлөвлөгөөг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор нээлтийн арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсугай.

2. Нээлтийн арга хэмжээний хөтөлбөрийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээнд зарцуулагдах 742,000 (Долоон зуун дөчин хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Нээлтийн арга хэмжээнд дүүргийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

АЖИЛ 2024 он ажил захирамж

1123200075

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 49 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



**“БҮТЭЭМЖ-ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЖИЛ”-ИЙН
НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

ЗОРИЛГО: Бүтээмжийн тухай ойлголт, төрийн байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх арга хэрэгсэл, байгууллага хоорондын хамтын ажиллагааг дээшлүүлэх “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэд, олон нийтэд сурталчлан таниулахад оршино.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар

ХУГАЦАА: 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 09.00 цагт

ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР: 1-р хорооны Соёлын ордон

ОРОЛЦОГЧ: Багахангай дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчид

№	Хөтөлбөрийн дараалал	Цаг, мин	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэх
1.	Хөтлөгч үг хэлэх (эхлэх)	09.00-10.03 цаг	Хөтлөгч О.Хулан	Н.Батцэнгэл
2.	Төрийн дуулал эгшиглүүлэх	09.03-09.05 цаг	Мэргэжилтэн Н.Батболд	Соёлын ордон
3.	Засаг дарга нээж үг хэлэх	09.05-09.15 цаг	Засаг дарга А.Сүхболд	М.Батсайхан
4.	Зорилтот жилийн төлөвлөгөө танилцуулах	09.15-09.30 цаг	Засаг даргын орлогч Б.Болормаа	Б.Гэрэлцолмон Б.Одбаяр
5.	Зорилтот жилийн төлөвлөгөөтэй холбогдуулан хэлэлцүүлэг зохион байгуулах	09.30-09.50	Хөтлөгч О.Хулан	Оролцогчид
6.	Цайны завсарлага	09.50-10.00	Б.Оюунгэрэл О.Батчимэг	-
7.	Бүтээмжийн тухай ойлголт, бүтээмжийг нэмэгдүүлэх суурь арга хэрэгслүүд	10.00-11.00	Багш МБТ-ийн зөвлөх Х.Ундраа	Оролцогчид
8.	Төрийн байгууллагын бүтээмжийн тухай ойлголт	11.00-11.50	Багш МБТ-ийн дэд захирал Ц.Батбилэг	Оролцогчид
9.	Хөтлөгч үг хэлэх (хаах)	11.50-12.00	Хөтлөгч О.Хулан	Б.Гэрэлцолмон

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн 793 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



“БҮТЭЭМЖ-ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЖИЛ”-ИЙН
НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Багшийн хөлс (Монголын бүтээмжийн төв)	ш	1	322,000	322,000
2	Багшийн хөлс (Хөтлөгч, модератор)	ш	1	300,000	300,000
3	Фото цаас	Боодол	2	20000	40,000
4	Принтерийн хор (өнгөт)	Ширхэг	6	10000	60,000
5	Бичгийн цаас	боодол	1	20000	20000
Нийт					742,000